

Голдож ба зэргэд

Даалгавар

- 1 Зөв тохируулан холбоорой.

Дэлхийн хэлбэр хэмжээг багасган үзүүлсэн загвар

Дэлхийн гадаргыг хавтгайд (цаасан дээр) буулгасан зураг



- 2 Дэлхийн загварт хаана юу байгааг гүйцээж тэмдэглээрэй.


Нөхөх үгс: хуурай газар, ус, хойд туйл, өмнөд туйл



- 3 Дэлхийн газарзүйн зураг дээрх үсгүүдийг аль нь хуурай газар, аль нь далайг нэрлэсэн болохыг ялган бичээрэй.

Хуурай газар:

Далай:



Даалгавар

Нөхөх үгс: газарзүйн зураг, тал бөмбөрцгийн карт, глобус


- 1 Тохирох үгийн нөхөж бичээрэй.

Дэлхийн хэлбэр хэмжээг багасган үзүүлсэн загварыг _____ гэнэ.


Дэлхийн гадаргыг тусгаг ашиглан хавтгайд (цаасан дээр) буулгасныг _____ гэнэ.

Дэлхийн гадаргын зөвхөн нэг тал нь бидний нүдэнд ил харагдаж нөгөө тал глобусын цаад талд байдаг тул харагдахгүй. Глобусыг хуваасан хоёр тал бөмбөрцгийг цаасан дээр буулгаж дүрсэлсэн зургийг _____ гэнэ.

- 2 Өгөгдсөн зүйлсийг нэрлээд, ижил ба ялгаатай талыг Эйлер-Веннийн диаграмм дээр тэмдэглээрэй.



- 3 Дэлхийн газрын зураг дээр хуурай газрыг []-д, далайг []-д нэрлэн бичээрэй. Зургаан тивийн нэрийг бичихдээ өмнө нь томоос бага руу эрэмбэлж дугаарлаарай.



Ус ба хуурай газар хэрхэн харагдахыг бичлэгээс үзээрэй.

<https://youtu.be/KDosftdo0rY>

Цэгийн байршил

Даалгавар

- 1 Өгөгдсөн зурагт тохирох түлхүүр үгийг нөхөж тодорхойлолтыг гүйцээгээрэй.
Голдож, зэргэд гэж юуг хэлэх вэ?



_____ гэдэг нь дэлхийн бөмбөрцөг дээрх хойд өмнөд туйлыг холбосон, газарзүйн зураг дээр босоо татагдсан шугамыг хэлнэ.


_____ гэдэг нь дэлхийн бөмбөрцөг дээрх хөндлөн цагираг, газарзүйн зураг дээр хөндлөн татагдсан шугамыг хэлнэ.




2

Глобус дээрх хоосон нүдэнд тохирох үгийг нөхөж бичээрэй.

Нөхөх үгс: экватор,
анхны голдож,
голдож, зэргэд,
хойд туйл, өмнөд туйл



- 4 Зураглалыг өөрийн үгээр тайлбарлаарай.



Миний бодлоор:

_____ харуулжээ.

Даалгавар

- 1 Эдгээр нь дэлхийн аль хэсгийг харуулсан зураг вэ? Нэрлээрэй.

Энэ хагаст ус ба хуурай газрын аль их вэ? Яагаад? _____



Энэ хагаст ус ба хуурай газрын аль их вэ? Яагаад? _____

- 2 Эдгээр нь дэлхийн аль хэсгийг харуулсан зураг вэ? Нэрлээрэй.

Энэ хэсэгт ус ба хуурай газрын аль их вэ? Яагаад? _____



Энэ хэсэгт ус ба хуурай газрын аль их вэ? Яагаад? _____

- 3 Дэлхийн хойд ба өмнөд, баруун зүүн хагасыг өнгөөр ялган будсан зураг байна.



Баруун хагас



Хойд хагас



Зүүн хагас



Өмнөд хагас



Дараах улсууд дэлхийн бөмбөрцгийн аль хагаст байгааг хүснэгтэд (✓) тэмдэглээрэй.

	Баруун	Зүүн	Хойд	Өмнөд	Дэлхийн аль хагаст оршдог вэ?
Монгол					
Австрали					
Америкийн нэгдсэн улс					